

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/26/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн Аудитын менежер: Л.Магсаржалам  
Утас: 88114867 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	16
3.5.3 Нэмэлт төсөв .....	16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
АЗЗА	Авто зам засвар арчлалт



“ХӨВСГӨЛ АЗЗА” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Б. ГАЛБАДРАХ ТАНАА

## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.15 № 01/071  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Дуусаагүй барилгын үлдэгдэл 64.8 сая төгрөг өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна. Энэ 2013 оноос хойш дуусаагүй барилга дансанд бүртгэгдсэн бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодорхой төсөв батлуулж хэсэгчлэн засварлаж ашиглалтад оруулж хөрөнгийн ашиглалтыг сайжруулах нь зүйтэй байна.

### Аудитын гол асуудал

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд 323.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 503.9 сая төгрөгийн авлага тайлагнасан байна. Тайлант онд Цемент шохой ТӨХК-д цемент авахаар 119.2 сая төгрөг шилжүүлсэн боловч 66.7 сая төгрөгийн цемент дутуу хүлээж авснаар авлага нэмэгдсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК нь 2022 оны зорилтот түвшний биелэлт 111.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	/төгрөгөөр/	
		Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,825,856.67	5,988,796.94
1.1.02	Дансны авлага	102,612,929.00	432,539,249.80
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	109,200.93	19,466,381.88
1.1.04	Бусад авлага	51,935,214.46	51,935,214.46
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.06	Бараа материал	195,150,709.25	266,037,947.95
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,503,474.48	1,503,474.48
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг- н бус хөрөнгө	0.00	0.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>354,137,384.79</b>	<b>777,471,065.51</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	941,457,199.43	828,626,652.27
1.2.02	Биет бус хөрөнгө	3,600,000.00	3,600,000.00
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,503,474.48	1,503,474.48
1.2.09	Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	206,804,600.00	206,804,600.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,153,365,273.91</b>	<b>1,040,534,726.75</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,507,502,658.70</b>	<b>1,818,005,792.26</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	46,935,951.49	145,109,154.98
2.1.1.02	Цалингийн өглөг	556,571.43	0.00
2.1.1.03	Татварын өр	25,335,737.42	126,103,896.02
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	52,536,530.99
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>72,828,260.34</b>	<b>323,749,581.99</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.2.01	Урт хугацаат зээл	448,747,239.00	448,747,239.00
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>448,747,239.00</b>	<b>448,747,239.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>521,575,499.34</b>	<b>772,496,820.99</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.3.01	Өмч: - төрийн	669,879,751.09	669,879,751.09
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	33,609,027.31	33,609,027.31
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	377,935,071.00	377,935,071.00
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>-95,496,690.04</b>	<b>-35,914,878.13</b>
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	61,045,212.16
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-95,496,690.04	-96,960,090.29
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>985,927,159.36</b>	<b>1,045,508,971.27</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,507,502,658.70</b>	<b>1,818,005,792.26</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,987,461,128.18	1,832,258,301.82
2	Борлуулалтын өртөг	1,738,958,257.08	1,526,176,607.50
3	Нийт ашиг( алдагдал)	248,502,871.10	306,081,694.32
8	Бусад орлого	0.00	873,972.72
8.1	Орлогын дүн	0.00	873,972.72
10	Ерөнхий ба удирдлагын зардал	247,106,686.18	239,127,653.52
12.1	Зардлын дүн	247,106,686.18	239,127,653.52
17	Бусад ашиг ( алдагдал)	4,837,455.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	4,837,455.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	6,233,639.92	67,828,013.52
19	Орлогын татварын зардал	623,363.99	6,782,801.36
20	Татварын дараах ашиг (алдагдал)	5,610,275.93	61,045,212.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	5,610,275.93	61,045,212.16

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2020 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	669,879,751.09	33,609,027.31	377,935,071.00	-83,350,205.97	998,073,643.43
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	5,610,275.93	5,610,275.93
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	-17,756,760.00	-17,756,760.00
09	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	669,879,751.09	33,609,027.31	377,935,071.00	-95,496,690.04	985,927,159.36
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	61,045,212.16	61,045,212.16
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	-1,463,400.25	-1,463,400.25
17	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	669,879,751.09	33,609,027.31	377,935,071.00	-35,914,878.13	1,045,508,971.27

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,714,039,680.00	1,655,941,884.50
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,706,855,851.00	1,640,447,882.20
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	35,000.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,048,829.00	134,002.30

1.1.6	Бусад мөнгөн орлого	6,135,000.00	15,325,000.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,599,241,616.29</b>	<b>1,696,660,003.23</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	575,865,052.85	529,931,619.93
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	226,428,694.28	67,633,856.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	469,342,602.00	409,561,383.49
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	545,902,706.53	77,054,029.69
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	614,271,131.00	521,075,234.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	16,515,968.13	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	143,491,436.50	59,051,253.44
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	1,064,025.00	3,808,526.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,360,000.00	28,544,100.00
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>114,798,063.71</b>	<b>-40,718,118.73</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>214,230,541.00</b>	<b>106,072,929.00</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,120,000.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	207,110,541.00	106,072,929.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>297,695,997.00</b>	<b>58,825,000.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	297,695,997.00	58,025,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	800,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-83,465,456.00</b>	<b>47,247,929.00</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>164,461,200.00</b>	<b>39,957,000.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	164,461,200.00	39,957,000.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>195,873,775.00</b>	<b>43,323,870.00</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	178,117,015.00	40,523,870.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	17,756,760.00	2,800,000.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>-31,412,575.00</b>	<b>-3,366,870.00</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-79,967.29</b>	<b>3,162,940.27</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,905,823.96</b>	<b>2,825,856.67</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,825,856.67</b>	<b>5,988,796.94</b>

**2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

д.д	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2022 гүйц-2022 төл	2022 гүйц /2022 төл
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	<b>1,987,461,128.2</b>	<b>1,652,478,800.0</b>	<b>1,833,132,274.5</b>	<b>180,653,474.5</b>	<b>110.9</b>
	а/ Улсын чанартай зам засвар арчлалт	948,729,785.5	923,618,100.0	1,108,983,895.5	185,365,795.5	120.1
	б/Орон нутгийн чанартай зам засвар, барилгын ажил	1,026,708,208.2	727,270,700.0	713,121,375.5	(14,149,324.5)	98.1

	в/ Бусад орлого	12,023,134.5	1,590,000.0	11,027,003.6	9,437,003.6	693.5
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,987,461,128.2</b>	<b>1,652,478,800.0</b>	<b>1,833,132,274.5</b>	<b>180,653,474.5</b>	<b>110.9</b>
3	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>1,986,064,943.3</b>	<b>1,581,178,500</b>	<b>1,765,304,261.0</b>	<b>184,125,761.0</b>	<b>111.6</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	247,106,686.2	260,846,400.0	239,127,653.5	(21,718,746.5)	91.7
4	Татварын өмнөх ашиг	6,233,639.9	71,300,300.0	67,828,013.5	(3,472,286.5)	95.1
5	Цэвэр ашиг /алдагдал/	5,610,275.9	64,170,200.0	61,045,212.2	(3,124,987.8)	95.1
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>350,322,431.1</b>	<b>309,618,400.0</b>	<b>321,263,126.1</b>	<b>11,644,726.1</b>	<b>103.8</b>
	а/Орлогын татварт	19,727,727.6	8,569,100.0	6,782,801.4	(1,786,298.6)	79.2
	б/ НӨТ	197,705,010.1	165,247,800.0	183,408,363.8	18,160,563.8	111.0
	в/НДШ	83,873,904.3	86,473,000.0	86,785,430.6	312,430.6	100.4
	г/Хүн амын орлогын татварт	44,465,989.1	44,286,000.0	39,823,014.3	(4,462,985.7)	89.9
	д/Үл хөдлөхийн татварт	1,800,000.0	1,800,000.0	1,800,000.0	-	100.0
	е/Гаалийн татварт	-	-	-	-	-
	ж/Тээврийн хэрэгслийн татварт	1,761,224.0	1,267,000.0	2,283,800.0	1,016,800.0	180.3
	и/Бусад татварт /Газар, ТТАМАТ/	988,576.0	1,975,500.0	379,716.0	(1,595,784.0)	19.2
7	Төрийн өмчийн ноогдол ашигт	17,756.7	32,085,100.0	2,800,000.0	(29,285,100.0)	8.7
8	Нийт ажиллагсдын тоо	41	41	41	-	100.0
9	Нийт цалингийн сан	534,915,420.0	529,442,000.0	504,354,200.0	(25,087,800.0)	95.3
10	Нэг ажилчны дундаж цалин	1,087,200.0	959,100.0	1,025,110.2	66,010.2	106.9
13	Борлуулалтын 1 төгт ноогдох зардал	1.00	0.00	0.96	1.0	100.6
14	Хөрөнгө оруулалт	122,183,310.0	189,530,000.0	52,750,000.0	(136,780,000.0)	27.8
15	<b>НИЙТ АВЛАГА</b>	<b>154,657,344.4</b>	<b>450,000,000.0</b>	<b>503,949,800.7</b>	<b>53,949,800.7</b>	<b>112.0</b>
	Үүнээс:Найдваргүй				-	
16	<b>НИЙТ ӨГЛӨГ</b>	<b>521,575,499.3</b>	<b>753,747,239.0</b>	<b>772,496,821.0</b>	<b>18,749,582.0</b>	<b>102.5</b>
	Үүнээс: Богино хугацаат	72,828,260.3	305,000,000.0	323,749,582.0	18,749,582.0	106.1
	урт хугацаат	448,747,239.0	448,747,239.0	448,747,239.0	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 “Хөвсгөл АЗЗА” ТӨХК ба түүний үйл ажиллагаа

Тус компани нь 100 хувь төрийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлнэ. Компанийн дүрмийг Төрийн өмчийн хорооны 2012 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 274 дүгээр тогтоолоор батлагдсан байна.

Компанийн үндсэн зорилт нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Хөвсгөл аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино.

Компани нь энэхүү дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор дор дурдсан үйл ажиллагааг эрхэлдэг.

- Компани нь улсын чанартай авто замын засвар арчлалт, шугамуудын хэсгүүдийг шуурхай удирдлагаар хангаж хариуцсан авто зам, замын байгууламжийн бүрэн бүтэн

байдалд байнгын хяналт тавьж, гарсан эвдрэл, гэмтлийг арилгах зохион байгуулан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

- Компани нь замын барилгын үйлдвэрлэл эрхэлж, тоног төхөөрөмж, машин механизмыг үр ашигтай ажиллуулах
- Компани нь авто замын засвар арчлалтын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан авто замын урт, тэдгээрийн дагуу байрлах шугаман албадын байршил, засвар арчлалтын ажлын нэгж, норм норматив, төсвийн норм үнэлгээ болон түрээсийн тоног төхөөрөмжийн машин цагийн норм үнэлгээг мөрдөж ажиллах
- Үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор харшлаагүй орлого, ашгаа нэмэгдүүлэхэд чиглэгдсэн бизнесийн бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл гаргана.
- Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэж байгаа нь хуульд нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүдийн цалин өмнөх оноос нэмэгдээгүй ба урамшуулал нэмэгдэл цалин олгоогүй байна. 2022 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн зардалд 31.4 сая төгрөг төлөвлөж, 31.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Гүйцэтгэх захирлын тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журмыг баталж, өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг тухай бүр хүргүүлэн ажилласан байна.

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Авто замын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 05 сарын 03-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх,

үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 сарын 20-ны өдрийн А/26 дугаар тушаалаар компанийн дотоод хяналтын нэгжийг 2 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 7 чиглэлээр 34 заалт бүхий ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 7 чиглэлээр 3 дугаар улиралд дотоод хяналтыг хийж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу гүйцэтгэх захирал 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккурэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу иж бүрэн бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/54 тоот тушаалаар “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг мөрдөж ажилладаг. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 310.5 сая төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2.8	5.9	3.1
Авлага	154.7	503.9	349.2
Бараа материал	195.1	266.0	70.9
Үндсэн хөрөнгө	942.9	833.9	-109.0

Биет бус хөрөнгө	3.6	0.0	-3.6
Хойшлогдсон татварын хөрөнгө	1.5	1.5	0.0
Газар / Биет бус хөрөнгө - Бусад /	206.8	206.8	0.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,507.5</b>	<b>1818.0</b>	<b>310.5</b>
Өр төлбөр	521.5	772.5	251.0
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	986.0	1045.5	59.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,507.5</b>	<b>1818.0</b>	<b>310.5</b>

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр өсч 5.9 сая төгрөгийг тайлант онд тайлагнасан байна.

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл байхгүй, Төрийн банк, Хаан банк, Хас банк, Голомт банканд харилцах данстай бөгөөд харилцах дансанд нийт 5.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Арилжааны банканд хугацаатай хадгаламж, тусгай зориулалттай мөнгөн хөрөнгө, замд яваа мөнгө байхгүй байна.

Тус компани нь дампуурсан болон төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан, Үндэсний хөрөнгө оруулалтын банканд мөнгө байршуулаагүй, харилцах дансгүй байна.

Авлагын үлдэгдэлд дотоодын байгууллагаас авах авлага 102,6 сая төгрөг, НДШ авлага 0,1 сая төгрөг, бусад авлага буюу хувь хүнээс авах авлага 51,9 сая төгрөгийг эзэлж байна.

Авлага данс тайлант онд өмнөх оноос 349.2 сая төгрөгөөр өссөн. Өмнөх оны авлагаас 102.6 сая төгрөг төлөгдөж, тайлант оны авлага 503.9 сая төгрөг буюу 326.5 хувиар өссөн байна. Үүнд:

- Тариалан сумын 2 км бетон зам барих гэрээт ажлын баталгааны барьцаа 98.4 сая төгрөг,
- УИХ-ын 88 дугаар тогтоолоор батлагдсан үнийн зөрүүний 210/2022-УИХ88 магадлалын дүгнэлтээр Хөвсгөл аймгийн ЗДТГ-аас авах авлага 266.7 сая төгрөг
- ИНЕГ-аас авах баталгааны барьцаа 0.5 сая төгрөг
- 2023 онд “Цемент шохой” ТӨХК-иас цутгалтын ажилд авах цементийн авлага 66.7 сая төгрөг
- НӨТ-ын авлага 19.4 сая төгрөг нь
- Хувь хүнээс авах авлага 51.9 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 452.0 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 51.9 сая төгрөгийн авлага байна. Иргэн С.Өлзийням Н.Болд-Эрдэнэ нараас авах авлагад бүртгэсэн 51.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар Н.Болд-Эрдэнэ нь эвлэрлийн гэрээ байгуулж, бараа материалаар барагдуулах хүсэлт тавьсан ч хуулийн байгууллагад хандахгүйгээр компанийн гүйцэтгэх удирдлага энэхүү зөвшилцлийг дангаараа хийх боломжгүй тул 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн №114 тоот албан бичгээр Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. Хөвсгөл аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 155/Ш32022/03439 тоот шийдвэрээр “Төрийн өмчит ашгийн төлөө хуулийн этгээд нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөхгүй тул” Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг ирүүлсэн байна.

Бараа материал тайлант онд өмнөх оноос 70.9 сая төгрөгөөр өссөн нь Тариалан сумын 2 км бетон авто зам барих ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хангамжийн материалын нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 109.0 сая төгрөгөөр буурчээ. Үүнд:

- Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 709 дугаар нийт 6 ширхэг 79.6 сая төгрөгийн тээврийн хэрэгслүүдийг дуудлага худалдаагаар худалдаж данснаас хассан.
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 тоот тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан чирэгч трейлер, өнгөт принтер тавилга эд хогшлыг 52.7 сая төгрөгөөр худалдан авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл нь 64.8 сая төгрөг нь өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна.

Урт хугацаат өр төлбөрөөр тайлагнасан 448.7 сая төгрөг нь Монгол улсын Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоолоор Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны урт хугацааны хөнгөлөлттэй төсвийн хүрээнд ТӨХ-ны 2009 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 3/1699 тоот албан бичгээр Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэж авсан боловч 2018 оны санхүүгийн аудитын тайлангаар урт хугацаат өр төлбөр рүү залруулж бүртгэсэн байна. Уг хөрөнгийг Зам тээврийн яам, Сангийн яам хооронд өр төлбөр тэглэх шийдвэр гарсны дараа эздийн өмчөөр бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэхээр хүлээгдэж байна.

Богино хугацаат өр төлбөр 250.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны дансны өглөгөөс зам барилгын материалын өглөг, тээврийн зардал, татварын өглөг зэрэг 72.8 сая төгрөгийн өглөг төлөгдсөн. Тайлант оны өр төлбөрийн дүнд богино хугацаат өр төлбөр 323.7 сая төгрөг бөгөөд үүний 144.4 сая төгрөг нь харилцагч байгууллагуудад өгөх өглөг 126.1 сая төгрөгийн өглөг нь татварын өглөг, 0.69 сая төгрөгийн өглөг нь ажиллагсдад төлөх хамтын сангийн өглөг, 52.3 сая төгрөг нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг байна.

Төрийн өмч 1,045.5 сая төгрөг бөгөөд өмнөх оноос 59.5 сая төгрөгөөр өссөн. Тайлант хугацааны цэвэр ашиг 61.0 сая төгрөг бөгөөд тайлант онд төрийн өмчийн ноогдол ашигт 2.8 сая төгрөг төлсөн байна.

### **3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 668 дугаар тогтоолоор “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,127.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 2,038.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан 2022 оны “Зам хариуцах гэрээ”-ний дүн буурч батлагдсанаар зорилтот түвшинд тодотгол хийж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор нийт орлогыг 1,650.8 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,581.2 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр 1,832.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,765.3 сая төгрөгийн зардал гарган, 61.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Нийт орлогын гүйцэтгэл 1,832.2 сая төгрөг байгаа нь төлөвлөснөөс 181.3 сая төгрөг буюу 10.9 хувиар их байна. Үүнд: А0902 Булган-Мөрөн чиглэлийн автозам дагуу амрах талбай буюу зогсоолын нэмэлт ажил, мөн үерийн улмаас улсын чанартай авто замд эвдрэл үүсч нэмэлтээр засвар арчлалтын ажил гүйцэтгэсэн нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,765.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 184.1 сая төгрөг буюу 11.6 хувиар их зарцуулсан гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Төлөвлөсөн авто замын ажлын тоо хэмжээ нэмэгдэж гол нөлөө үзүүлсэн
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн А/20 дугаар тушаалаар хээрийн нэмэгдлийн зардал нь 7,200 төгрөгөөс 9,800 төгрөг болж өөрчлөгдсөн нь нөлөөлсөн
- Шатах, тослох материал болон зам барилгын материалын үнийн өсөлтөөс тус тус шалтгаалсан байна.

Хүснэгт 2. 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

Д-д	Үзүүлэлт	2021 оны гүйцэтгэл	2022		Харьцуулалт	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэл</b>	<b>1,987.46</b>	<b>1,650.89</b>	<b>1,832.26</b>	<b>181.36</b>	<b>110.99</b>
	а/ Улсын чанартай зам засвар арчлалт	948.73	923.62	1,108.98	185.37	120.07
	б/Орон нутгийн чанартай зам засвар, барилгын ажил	1,026.71	727.27	713.12	(14.15)	98.05
	в/ Бусад орлого	12.02	1.59	10.15	8.56	638.36
2	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>1,987.46</b>	<b>1,650.89</b>	<b>1,832.26</b>	<b>181.36</b>	<b>110.99</b>
3	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>1,986.00</b>	<b>1,581.20</b>	<b>1,765.30</b>	<b>184.10</b>	<b>111.64</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	247.11	260.85	239.13	(21.72)	91.67
4	Татварын өмнөх ашиг	6.23	71.30	1,830.49	1,759.19	2,567.30
5	Цэвэр ашиг /алдагдал/	5.61	64.17	61.05	(3.13)	95.13
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>350.32</b>	<b>309.18</b>	<b>321.26</b>	<b>12.09</b>	<b>103.91</b>
	а/Орлогын татварт	19.73	8.57	6.78	(1.79)	79.15
	б/ НӨТ	197.70	165.25	183.41	18.16	110.99
	в/НДШ	83.87	86.47	86.79	0.31	100.36
	г/Хүн амын орлогын татварт	44.47	44.29	39.82	(4.46)	89.92
	д/Үл хөдлөхийн татварт	1.80	1.80	1.80	-	100.00
	е/Гаалийн татварт	-	-	-	-	-
	ж/Тээврийн хэрэгслийн татварт	1.76	0.90	2.28	1.38	253.76
	и/Бусад татварт /Газар, ТТАМАТ/	0.99	1.90	0.38	(1.52)	19.98
7	Төрийн өмчийн ноогдол ашигт	17.76	32.00	2.80	(29.20)	8.75
8	Нийт ажиллагсдын тоо	41.00	41.00	41.00	-	100.00
9	Нийт цалингийн сан	534.92	529.44	504.35	(25.09)	95.26
10	Нэг ажилчны дундаж цалин	1.09	0.96	1.03	0.07	106.88
13	Борлуулалтын 1 төг-т ноогдох зардал	1.00	0.96	0.96	0.01	100.59
14	Хөрөнгө оруулалт	305.30	189.53	52.7	52.6	27.8
15	<b>НИЙТ АВЛАГА</b>	<b>154.66</b>	<b>450.00</b>	<b>503.94</b>	<b>53.94</b>	<b>111.99</b>
	Үүнээс:Найдваргүй				-	
16	<b>НИЙТ ӨГЛӨГ</b>	<b>73.28</b>	<b>753.75</b>	<b>324.20</b>	<b>(429.55)</b>	<b>43.01</b>
	Үүнээс: Богино хугацаат	72.83	305.00	323.75	18.75	106.15
	урт хугацаат	448.75	448.75	448.75	-	100.00

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлага, өглөгийг зохистой түвшинд бууруулж ажиллах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн аудитын менежер Л.Магсаржалам гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

“Хөвсгөл АЗЗА” ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 39.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 27.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 53.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 53.2 сая зөрчилд 4 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	53.1	3	1.3	75
Нийт дүн	4	53.1	3	1.3	75

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Урт хугацаат өр төлбөрөөр тайлагнасан 448.7 сая төгрөгийг Монгол улсын Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоолоор Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны урт хугацааны хөнгөлөлттэй төсвийн хүрээнд ТӨХ-ны 2009 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 3/1699 тоот албан бичгээр Эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэж авсан боловч 2018 оны санхүүгийн аудитын тайлангаар урт хугацаат өр төлбөрт залруулж бүртгэсэн байна. Тайлант онд урт хугацаат өр төлбөрийг барагдуулах талаар шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 261.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 261.5 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд төлөвлөсөн орлогоос илүү орлого нэмэгдсэнтэй холбоотой зардал өсөж зорилтот түвшингээр баталсан нийт зардлаас 184.1 сая төгрөгөөр хэтрүүлсэн

байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2022 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 03 дугаар тогтоолоор тодотгол хийсэн зорилтот түвшинтэй нийцэхгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 “үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, Компанийн дүрмийн 10.11 дүгээр зүйлд заасан гүйцэтгэх захирлын эрх, үүргийн заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд батлагдсан зорилтот түвшнийг ханган, зардал хэтрүүлэхгүй ажиллах.

## **2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, бөөн дүнгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлагналын "Үнэлгээ ба хэмжилт" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал дансанд ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэж байх.

## **3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайланг бэлтгэж, хойшлогдсон татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2020 оны 144 дүгээр “Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам, тайлангийн маягт, аргачлал батлах тухай” тушаалыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүгийн тайланг бэлтгэж, санхүүгийн тайланд тусгах.

## **4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Хөвсгөл АЗЗА ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд 323.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр, 503.9 сая төгрөгийн авлага тайлагнасан байна. Тайлант онд Цемент шохой ТӨХК-д цемент авахаар 119.2 сая төгрөг шилжүүлсэн боловч 66.7 сая төгрөгийн цемент дутуу хүлээж авснаар авлага нэмэгдсэн байна. Авлага, өр төлбөр өндөр дүнтэй байгаа нь төлбөр түргэн барагдуулах чадварт сөрөг нөлөө үзүүлж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг зөрчсөн, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага, өр төлбөрийг барагдуулж, цаашид нэмэхгүй байх.

## **5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Дуусаагүй барилга дансанд 64.8 сая төгрөгөөр бүртгэлд тусгагдсан, 2013 оноос хойш ашиглалтад оруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-д “төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах; заалтыг зөрчсөн, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодорхой төсөв хөрөнгийг батлуулж хэсэгчлэн засварлаж ашиглалтад оруулж, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Баталсан зардлыг хэтрүүлсэн	1	184.1					1	184.1				
ШТС-аас авсан шатахууныг нэр төрөл, тоо хэмжээгээр орлого зарлагаар тухай бүр бүртгэхгүйгээр, бөөн дүнгээр бүртгэсэн	1	11.1					1	11.1				
Татварын зөрүүгийн тайлан бэлтгэж, татварын зөрүүг санхүүгийн тайланд тусгаагүй	1	1.5					1	1.5				
Авлага, өр төлбөр өндөр дүнтэй байгаа	1	-					1	-				
Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах	1	64.8					1	64.8				
<b>Нийт</b>	<b>5</b>	<b>261.5</b>					<b>5</b>	<b>261.5</b>				

АУДИТЫН ТАЙЛАНГ  
ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Х.ДИЙМАА

Л.МАГСАРЖАЛАМ

